



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 03 дугаар сарын 10 өдөр

Дугаар 15

Хэрлэн сум

XV ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын XV хурал 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 15:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 96,7 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Коронавируст халдвар (COVID19)-аас урьдчилан сэргийлэх, олноор нэг дор цуглахгүй байх үүднээс аймгийн Онцгой комиссын хурлыг аймгийн Онцгой комиссын ажиллах журмын 1.8-д заасны дагуу цомхотгосон хэлбэрээр хуралдуулахыг гишүүдэд танилцуулж шийдвэр гаргуулах тухай Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах:

2. Дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зарцуулах журмын төслийг хэлэлцүүлэн Онцгой комиссын хурлын шийдвэрийг гаргуулах тухай Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах:

3. Улсын Онцгой комиссын 05 дугаар тогтоолоор авто тээврийн зорчих хөдөлгөөнийг хязгаарласантай холбогдуулан хот, аймаг, сум хоорондын хүнсний болон ачаа тээвэрлэлтийг хэвийн явуулах, хүндэтгэн үзэх шалтгааныг гэдгийг тодорхой болгох талаар Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах:

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга,
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

1.1. Хүндэтгэн үзэх шалтгааныг үндэслэн нийслэл, аймаг, сумдад зорчих тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зөвхөн аймгийн Онцгой комиссын орлогч, Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын даргын зөвшөөрлөөр, сум хооронд болон аймгийн төв рүү зөвхөн сумын Засаг дарга, Онцгой комиссын даргын зөвшөөрлөөр нэвтрүүлэхийг,

1.2. Хүндэтгэх үзэх шалтгааны дагуу дараах байдлаар зөвшөөрөл олгоно.
Үүнд:

Хөдөлмөрийн тухай хууль: 74.2-т заасан хойшлуулшгүй яаралтай ажил гүйцэтгэх,

74.2.Хамтын болон хөдөлмөрийн гэрээнд тохиролцоогүй бол дор дурдсанаас бусад тохиолдолд ажилтныг ажил олгогчийн санаачилгаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно:

74.2.1.улс орныг батлан хамгаалах, хүний амь бие, эрүүл мэндийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай ажил гүйцэтгүүлэх;

74.2.2.гамшиг, аюулт үзэгдэл, ослоос сэргийлэх, тэдгээрийн хор уршгийг нэн даруй арилгах;

74.2.3.нийтийн усан хангамж, цахилгаан, дулааны эрчим хүч, тээвэр, холбооны хэвийн ажиллагааг алдагдуулсан гэмтлийг арилгах;

74.2.4.урьдчилан мэдэх боломжгүй бөгөөд яаралтай хийхгүй бол аж ахуйн нэгж, байгууллагын буюу түүний салбар, нэгжийн хэвийн үйл ажиллагаанд учирч болзошгүй саадыг арилгах хойшлуулшгүй ажил гүйцэтгүүлэх.

Албан томилолт: Тусгай ажлын шаардлагаар зорчих албан тушаалтан нь байгууллагын албан томилолт нотлох баримтын хамт аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад хүсэлт гаргасан байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ: Сумаас Бүсийн оношилгоо эмчилгээний төвд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахад тухайн сумын Эрүүл мэндийн төвийн даргын дүгнэлт, АМ-13А маягт, сумын Засаг дарга, Онцгой комиссын даргын зөвшөөрлийн хамт,

Улаанбаатар хот руу АМ-13А маягт, Эмнэлэг хяналтын комиссын шийдвэр аймгийн Онцгой комиссын орлогч даргын зөвшөөрлөөр,

Ар гэрийн гачигдал: Зөвхөн төрсөн талын гачигдлыг хүлээн авч нотлох баримтуудыг үндэслэн Онцгой комиссын орлогч даргын зөвшөөрлөөр,

Ачаа тээвэр: Тухайн байгууллагын тодорхойлолт, жолоочоос гадна нэг зорчигчтой байна.

1.3. Аймгийн Шуурхай штабаас хүндэтгэн үзэх шалтгаанаар нэвтрэх зөвшөөрлийг үдийн өмнө 09:00-12:00 цаг, үдийн завсарлага 12:00-14:00 цаг, үдийн дараа 14:00-18:00 цаг хүртэл гэсэн цагийн хуваарийн дагуу олгож ажиллахыг,

1.4. Онцгой комиссын ажиллах журмын 1.8 дахь заалт мөн коронавирусын халдвар /COVID-19/-аас урьдчилан сэргийлэх, олноор нэг доор цуглахгүй байх үүднээс аймгийн Онцгой комиссын хурлыг цомхотгосон хэлбэрээр зохион байгуулж байхыг,

1.5. "Дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зарцуулах журам"-ыг аймгийн Онцгой комиссын гишүүд 100 хувийн саналаар дэмжиж баталсан тул үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг,

1.6. Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн бараа, материалаас аймгийн Улаан загалмайн хороонд хамгаалах хувцас-10 ширхэг, Чойбалсан нисэх буудалд амны хаалт-10 ширхэг, хамгаалах хувцас-5 ширхэг, Хэвлэл мэдээллийн байгууллагуудад амны хаалт 86 ширхэгийг тус тус олгохыг,

1.7. Зорчигч тээврийн хөдөлгөөнийг шалган нэвтрүүлэх хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын хоолны зардал 3,060,000 төгрөг, шатахууны зардал 3,492,000 төгрөг, нийт 6,552,000 төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас олгохыг,

Гурав. Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын

гишүүн Ч.Оюунаад:

3.1. Улаанбаатар хот, Дорноговь аймгийн Замын Үүд сумаас ирсэн иргэдэд ямар нэгэн зовиур илэрвэл Эрүүл мэндийн газрын 70583355 дугаарын утсаар хандаж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, зөвлөгөө авч байх чиглэлээр ард, иргэдэд мэдээлэл хүргэж ажиллахыг,

3.2. Хүн олноор цугларч үйлчилгээ авдаг Нэг цэгийн үйлчилгээ, Улсын бүртгэлийн хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газруудад халуун хэмжигч тус бүр 1 ширхэгийг олгохыг,

Дөрөв. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын
хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн О.Байгалмаад:

4.1. Коронавируст халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд жирэмсэн болон 0-5 насны хүүхэдтэй эх, өрх толгойлсон эцгийг гэрээсээ ажиллах нөхцөл боломжоор хангах, цалинтай чөлөө олгох тухай захирамжийг боловсруулж танилцуулахыг,

Тав. Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа, Гадаадын иргэн, харъяатын газрын
Зүүн бүс дэх газрын дарга Б.Тамир нарт:

5.1 Бусад улсаас ирсэн Дорнод аймгийн харъяат иргэдийн мэдээллийг Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газар, Тагнуулын газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газарт албан бичгээр ирүүлэх, "Telegram" аппликэйшнд мэдээллийг байршуулахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГА



М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА

Д.БАТТУЛГА